

БАТЛАВ.  
ДЭРЭН СУМЫН  
ЗАСАГ ДАРГА



АМАРТҮВШИН

БАТЛАВ  
“ЗАНДО ЭЛЕКТРОНИКС” ХХК  
ЗАХИРАЛ А ЭРДЭНЭМӨНХ



“ДУНДГОВЬАЙМГИЙН ДЭРЭН СУМЫН “ЭМТ – ГАЛ ТОГООНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ”  
НИЙЛҮҮЛЭХ АЖЛЫН ГЭРЭЭ

Дугаар № ДУГАДСЗДТГ/20231222

2023-03-15

Дэрэн сум

Нэг талаас [Дундговь аймгийн Дэрэн сумын ЗДТГ-ЭМТ ] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [“ЗАНДО ЭЛЕКТРОНИКС” ХХК ] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2023 оны 03 дугаар сарын 15-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

19. Монгол Улсын Иргэний хууль, болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
20. Захиалагч нь Дэрэн сумын “ЭМТ ГАЛ ТОГООНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ” –д тоног төхөөрөмж нийлүүлэх суурилуулах ажилд “ДУГАДСЗДТГ-/20231222 дугаартай ажлыг (цаашид “ажил” гэх) 6565000 (зургаан сая таван зуун жаран таван мянган ) төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв.
21. Захиалагч нь Дэрэн сумын “ЭМТ ГАЛ ТОГООНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ” ажлын 6565000 (зургаан сая таван зуун жаран таван мянган ) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлнэ.
22. Гэрээний үнэ санхүүжилтийг ажил гүйцэтгэсний дараа 100 хувь олгож санхүүжүүлнэ. Гүйцэтгэгч нь Дэрэн сумын “ЭМТ ГАЛ ТОГООНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ” –д нийлүүлэх ажлыг 2023 оны 04 дугаар сарын 15 -ны дотор нийлүүлэн хүлээлгэн өгнө. Ажил хүлээн авснаас хойш үлдэгдэл 100 хувийн санхүүжилтийг олгоно.
23. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
  - Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  - Гэрээ байгуулах тухай тушаал
  - Бусад шаардлагатай баримт бичиг
  - Гэрээний тусгай нөхцөл;
  - Гэрээний ерөнхий нөхцөл;
  - Техникийн үзүүлэлт
  - Санхүүжилтийн хуваарь;
24. Гэрээ нь дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болно.
25. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

26. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
27. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлага хүлээж байна.
28. Гүйцэтгэгч нь техникийн үзүүлэлтийн дагуу шаардлага хангаагүй тоног төхөөрөмж нийлүүлсэн бол буцаах саналыг захиалагч тавина.
29. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
30. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.
31. Гэрээнд заасан ажлыг хугацаандаа нийлүүлээгүй тохиолдолд хэтэрсэн хоног тутамд үнийн дүнгийн 0,3 хувиар алданги ногдуулна. Гэхдээ алданги хүлээснээр үүргийн гүйцэтгэлээс чөлөөлөгдөхгүй.
32. Захиалагч нь Шилэн дансны тухай хуулийн 3.1.4, 3.1.5, 6.9-т заасны дагуу мэдээллийг оруулах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
33. Захиалагч нь гүйцэтгэгчийн төлөөлөлтэй ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргах. Ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх.

#### Маргаан шийдвэрлэх

34. Талууд энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой үүссэн маргааныг харилцан тохиролцоо замаар шийдвэрлэхийг эрхэмлэнэ.
35. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргаж асуудлыг шийдвэрлүүлнэ.
36. Энэхүү гэрээг 4 хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгална.

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

##### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ДЭРЭН СУМЫН ЭМТ  
ЭРХЛЭГЧ *Ю. Янжиндулам* Ю. ЯНЖИНДУЛАМ

##### ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“ЗАНДО ЭЛЕКТРОНИКС” ХХК  
МЕНЕЖЕР *Т. Урангоо* Т. УРАНГОО

